



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 онь 05 сарын 13 өдөр

Дугаар А/254

Хэрлэн сум

Өндөрхаан хайрхныг тахирад
зориулж хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Билгийн тооллын зуны тэргүүн сарын шинийн аравны өдрийг тохиолдуулан Өндөрхаан хайрхныг тахирах арга хэмжээнд зориулж Сэцэнханы хүрээ Гүндгаравлин хийдэд 7,119,440 (долоон сая нэг зуун арван есөн мянга дөрвөн зуун дөчин) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2.Дээрх арга хэмжээний зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжгүй байсан нэг удаагийн шинжтэй арга хэмжээний зардлаас олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Гантулга)-д, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайханд)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ